**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 18 өдөр Дугаар A/637

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Улаанбаатар хотын хүнсний хог хаягдал дахин боловсруулах төсөл"-ийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 33,543,659.80 (гучин гурван сая таван зуун дөчин гурван мянга зургаан зуун тавин есөн төгрөг наян мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар сургууль (Ч.Алтансүх)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар сургууль (Ч.Алтансүх)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/651 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар сургууль

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Ашиглалтад авсан он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэлд авах | | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нэгжийн үнэ | Нийт үнэ | |
| 1 | Бутлагч бага оврын төхөөрөмж | | 2024 | Шинэ | ш | 1 | 20,250,806.2 | 20,250,806.2 | Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл |
| 2 | Бордоо савлах уутны ам дарагч машин | | 2024 | Шинэ | ш | 1 | 1,483,013.6 | 1,483,013.6 | |
| 3 | Бордоо боловсруулах дундын эзэмшлийн хайрцаг W1 | | 2024 | Шинэ | ш | 1 | 11,809,840.0 | 11,809,840.0 | |
| **Нийт бүртгэх хөрөнгийн дүн** | | | | | | | | **33,543,659.8** | |